

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ ОРУУЛАХ САНАЛ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

2026 оны 03 дугаар сарын 27

Улаанбаатар хот

№	Ерөнхий чиглэл	Сувилагч	Бусад мэргэжилтэн	Туслах сувилагч	Тайлбар
1.	Эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох /эрх, үүрэг /	<p>Сувилагчийн эрх үүргийг тодорхой болгох</p> <ul style="list-style-type: none">• Эрх: "Сувилагч өөрийн мэргэжлийн түвшинд сувилахуйн онош тавих, сувилахуйн төлөвлөгөөг бие даан боловсруулж, гүйцэтгэлийг үнэлэх"• Үүрэг: "Сувилахуйн тусламж үйлчилгээний үед гарсан алдаа, эрсдэлийг мэдээлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд манлайлах."• Ажил үүргээ гүйцэтгэх явцад гуравдагч этгээдийн халдлагаас төр хамгаалах үүргийг тусгаж өгөх, халдсан тохиолдолд хариуцлагыг чангатгах заалт оруулах		<ul style="list-style-type: none">• Туслах сувилагчийг эрх, үүргийг тодорхой тусгах өгөх• <p>Мэргэжлийн ангилал:</p> <ul style="list-style-type: none">• Туслах сувилагчийг "Эрүүл мэндийн туслах ажилтан" гэсэн бие даасан ангилалд оруулж, зөвхөн богино хугацааны сургалтаар биш, тодорхой сертификаттайгаар ажилладаг болох.	<ul style="list-style-type: none">• Эмнэлгийн практикт сувилагч, эмч нар өндөр ачаалалтай, сэтгэлзүйн дарамттай орчинд ажиллаж байгаа нь ажлын гүйцэтгэл болон эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа гэмтэл, мэс заслын тасагт ажиллах үед эрсдэл өндөр, ажлын ачаалал их байдаг.

		<ul style="list-style-type: none"> • Сувилагчийг мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал хамруулах • Эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, халдлага, дарамтаас хамгаалах эрх зүйн зохицуулалт. /Иргэдээс хамгаалах / 			
2.	Биеэ даасан тусламж үйлчилгээг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн бие даасан байдал ба үүргийг тодорхойлох • Бие даасан шийдвэр гаргалт: Сувилагч мэдлэг, ур чадварын хүрээнд сувилахуйн онош тавих, сувилах төлөвлөгөө боловсруулах, үр дүнг үнэлэх эрхийг тодорхой заах. • Төрөлжсөн сувилагчийн эрх: Нарийн мэргэшсэн (эрчимт эмчилгээ, мэс засал, хавдар гэх мэт) сувилагчдын гүйцэтгэх тусгай үүрэг, хүлээх хариуцлагыг зааглах. • Мэргэжлийн чиглэлээр нь мэргэшлийн зэрэг олгох / Яаралтай тусламжийн зөвлөх сувилагч...../ • Сургалт, зааварчилгаа: Оюутан болон туслах сувилагчийг удирдаж, зааварчилгаа өгөх 		<ul style="list-style-type: none"> • Хийх ажил үүргийг тодорхой болгох: Туслах сувилагчийн хийх ажлыг (жишээ нь: өвчтөнийг хооллох, угаах, хөдөлгөх, ор засах) стандартын дагуу баримтжуулдаг болох. • Туслах сувилагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг нэгдсэн стандартад оруулж, чанарын хяналтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хянадаг байх • Туслах сувилагчийг мэргэшүүлэх, шатлан суралцах боломжийг төр болон ажил олгогч бодлогоор дэмжинэ. 	<ul style="list-style-type: none"> • Сувилагчийг бие даасан мэргэжилтэн гэж хуульд тодорхойлох • Сувилагчийг зөвхөн "эмчийн туслах" биш, сувилахуйн тусламж үйлчилгээг бие даан үзүүлэх эрхтэй мэргэжилтэн гэж хуульчлах шаардлагатай. • Мэргэжлийн сувилагч зөвхөн тариа, дусал, шархны боолт зэрэг нарийн ажилдаа төвлөрөх боломж бүрдэнэ.

		"сургагч сувилагч"-ийн эрхийг хуульчлах.			
3.	Сувилахуйн тусламж үйлчилгээний стандарт, чанарын хяналтыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Сувилахуйн аудит: Эмнэлэг бүр "Сувилахуйн чанарын хяналтын баг"-тай байх бөгөөд уг баг нь эмчийн хяналтаас хараат бусаар сувилагчийн ажлыг үнэлдэг байх. 			
4.	Хүний нөөцийн хөгжлийг дэмжих	<ul style="list-style-type: none"> Сувилагч мэргэжилтний карьерийн хөгжил, мэргэжлийн ур чадвараар нь ангилж (N1-N5), цалингийн шатлалтай холбох. Мэргэжлээрээ хөгжих боломжийг бодлогоор дэмжих, Мэргэжлээрээ доктор, магистр, бакалавр зэрэгтэй сувилагч нарын албан тушаалыг тодорхой болгох, ажил үүргийг хуульчилж өгөх 		<ul style="list-style-type: none"> Хөнгөвчлөх эмчилгээ, ахмад настны асаргаа, сэргээн засах тасгуудад туслах сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн ур чадварын ангиллыг, цалингийн шатлалтай холбож ангилвал сувилагч нар мэргэжил боловсролоо тасралтгүй дээшлүүлэхэд маш том түлхэц болно.
5.	Сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> 1 сувилагчид ноогдох эмчлүүлэгчийн дээд хязгаарыг тогтоох илүү эмчлүүлэгчтэй ажилласан бол ачаалалд тохируулах нэмэгдэл хөлсийг тогтоох 1 сувилагч болон 1 оронд ноогдох сувилагчийн тоог хуульчилж тогтоож өгөх (жишээ нь: Эрчимт эмчилгээнд 1:2, энгийн тасагт 1:8 гэх мэт) 			

		<ul style="list-style-type: none">• Гэрээр үзүүлэх сувилахуй: Сувилагч нар бие даан "Сувилахуйн төв" эсвэл "Гэрийн сувилахуйн үйлчилгээ" эрхлэх эрх зүйн орчныг хялбарчлах.• Цахим сувилахуй (Tele-nursing): Архаг өвчтэй болон хэвтрийн өвчтөнд цахимаар зөвлөгөө өгөх, хяналт тавих үйлчилгээг албан ёсны тусламжийн төрөлд оруулах.• Түгээмэл үйлдлийн стандартыг шинэчилж, тус стандартад эмч нарыг 1 баг гэдгээр нь үзэж илүү хамтарсан байдлаар оруулах• Гэрээр үзүүлэх сувилгаа: Гэрээр болон хөнгөвчлөх сувилахуйн үйлчилгээг албан ёсоор төрөлжүүлж, даатгалаас санхүүжүүлнэ.• Ард иргэд, үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн боловсрол, эрүүл зан үйлийг хэвшүүлэх тал дээр сувилагч мэргэжилтэн явуулдаг эрхтэй болгох, нийгмийн эрүүл мэндийн сувилахуйг дэмжих			
--	--	--	--	--	--

6.	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй орчин бүрдүүлэлт				
7.	Нийгмийн баталгаа	<ul style="list-style-type: none"> • Ажиллах аюулгүй орчин сэтгэл зүйн хамгааллыг оруулах эрүүл мэндийн даатгалыг энгийн иргэдээс өөрөөр болгох • Цалин хөлс, урамшуулал дээр эрсдэлийн нэмэгдлийг өгөх /халдварт өвчин, идээт шархны халдвар тэмбүү, Дох/ • Сувилагч мэргэжилтнийг ажилласан жилд нь тохируулж орон сууцаар хангах • Сувилагч мэргэжилтнийг бусад татвараас чөлөөлөх • Илүү цагийн хөлсийг татвараас чөлөөлөх • Мэргэжлийн эрсдэлийн даатгал: Ажлын явцад халдвар авах, гэмтэх эрсдэлийг ажил олгогч 100% даатгах. • Орон сууцны хөнгөлөлт: 10-аас дээш жил тасралтгүй ажилласан сувилагчийн ипотекийн зээлийн хүүг төрөөс татаас хэлбэрээр дэмжих, 			<ul style="list-style-type: none"> • Сувилагч мэргэжилтэн ажлын ачаалал маш өндөр байдаг, ажлын хөлсөндөө тохирсон цалин хөлс авах эрхтэй. • Сувилагч нар үндсэн ажлын цагаасаа гадна 1.5-2 дахин их ачаалалтай ажиллаж байна.

		<p>бага хөлстэйгээр түрээслэх</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн салбарын онцлогийг харгалзан тэтгэврийн нас, тэтгэмжийн хэмжээг өөрчлөх • "Эрүүл мэндийн ажилтны үндсэн ажлын цагаас илүү ажилласан цагийн нэмэгдэл хөлс болон шөнийн ээлжийн нэмэгдэл хөлсийг Хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх • Тэтгэмж, урамшуулал: Мэргэшсэн зэрэг, ур чадварын нэмэгдлийг тогтмолжуулж, хуульд тусгаж өгөх 			
8.	Бусад зүйл	<ul style="list-style-type: none"> • Шөнийн ээлж, илүү цагийг өндөр хувиар бодох (хуульчилсан хувьтай) • Гадаад сургалтанд хамрагдах зардал мөнгийг холбогдох яам байгууллага гаргах • Дарамт шахалтаас хамгаалах: Ажлын байран дээр үйлчлүүлэгчээс ирж буй бие махбод болон сэтгэл зүйн хүчирхийллээс сувилагчийг хамгаалах, хохирогч болсон тохиолдолд эмнэлэг нь 	<ul style="list-style-type: none"> ✓ Сургуулийн хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэгийг оруулах ✓ Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай иргэдийн эрхийг хамгаалах тусгай заалт ✓ Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, сургалт, мэргэшлийг 	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр хамгаалал: Туслах сувилагч нар нь хүнд өвчтөнийг өргөх, зөөх зэрэг ачаалал ихтэй ажил хийдэг тул "Нуруу нугасны гэмтлээс сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал"-ын тоног төхөөрөмжөөр (өргөгч, тэргэнцэр гэх мэт) хангахСэтгэл зүйн аюулгүй байдал: 	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийллээс хамгаалах: Ажлын байран дээр сувилагч, туслах сувилагчийг доромжлох, бие махбодийн халдлага үйлдэхээс хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг чангатгаж, байгууллага нь ажилтнаа хууль зүйн дагуу өмгөөлөх үүрэг хүлээнэ. Эрсдэлтэй нөхцөлд ажиллагсад тусгай сангаас

		<p>хууль зүйн болон сэтгэл зүйн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> • Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөн болон ар гэрийн хэл амаар доромжлох нь батлагдсан үед торгуулийн арга хэмжээг авч тухайн ажилтны сэтгэл санааны хохиролыг барагдуулах / ямар хүн арга хэмжээ авах нь тодорхой болгох/ • Эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулна. • Ажил үүргээ гүйцэтгэх явцад: эрүүл мэндээр хохирсон тохиолдолд даатгалаар бүрэн нөхөн төлөх • Ээлжийн болон яаралтай тусламжийн ажилтнуудын ажлын цагийг хуульчилж, хэт ачаалалтай ажиллахыг хязгаарлах. • Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай иргэдээс эрүүл иргэдийн эрхийг хамгаалах тусгай заалт • 	<p>дэмжих ажиллах орчин нөхцөлийг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> ✓ Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалд багтаах ✓ Мэс заслын өмнө болон дараах хугацаанд тамхи хэрэглэхийг хязгаарлах эрх зүйн зохицуулалт бий болгох Энэхүү заалтыг зөрчвөл мэс заслын дараах эрсдлийг бичгээр зөвшөөрөл авах заалт оруулах ✓ Эмнэлгийн орчныг өргөтгөсөн тамхигүй бүс болгон хуульчлах ✓ Электрон тамхи , Вейпийг , сургуулийн орчимд бүрэн хориглох 0-18 насны насанд хүрээгүй иргэдэд борлуулах худалдах заалтыг оруулах 	<p>Өвчтөн болон ар гэрийнхний зүгээс ирдэг "бага тушаалын ажилтан" гэж үл тоомсорлох, дээрэлхэх хандлагаас хамгаалах дотоод журам, ёс зүйн дүрмийг чангатгах.</p> <ul style="list-style-type: none"> • Татварын чөлөөлөлт: Туслах сувилагч нар ихэвчлэн бага цалинтай, хүнд нөхцөлд ажилладаг. Тиймээс тэдний шөнийн ээлж болон илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг Хүн амын орлогын албан татвараас (ХОАТ) 100% чөлөөлөх. • Карьерын өсөлт: Туслах сувилагчаар 3-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан хүнийг Мэргэжлийн сувилагч болохоор суралцахад нь сургалтын 	<p>дэмжлэг авах эрхтэй байх</p> <ul style="list-style-type: none"> • Эдгээр өөрчлөлтийг хэрэгжүүлснээр эмчилгээний үр дүн сайжрах, хүндрэл буурах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой гэж үзэж байна. • Эмнэлгийн практикт тамхи хэрэглэдэг өвчтөнүүдэд шарх эдгэрэлт удаашрах, халдвар нэмэгдэх, мэс заслын дараах хүндрэл өсөх зэрэг асуудал түгээмэл ажиглагдаж байна. •
--	--	---	---	--	--

			✓ Сэтгэлзүйн зөвөлгөө ,эм эмчилгээг - даатгалаас хөнгөлөх , үнэгүй болгох санал	төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх эсвэл төрөөс дэмжлэг үзүүлэх.	
--	--	--	--	--	--

Жич: Дараах слайдаас хуулийн холбогдох мэдээллийг авна уу.

ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭ



Эрүүл мэндийн тухай	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай	Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай
<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</p> <ul style="list-style-type: none"> - ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ - ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ - ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО - ТАВДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО - ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА - ДОЛДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ - НАЙМДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО 	<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой нэр томъёны тодорхойлолтууд.</p> <p>ДОЛДУГААР БҮЛЭГ Магадлан итгэмжлэл</p> <p>Гадаад эмчилгээ</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</p> <p>ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ</p> <p>ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ төрөл</p>	<ul style="list-style-type: none"> - ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА - Зөвшөөрөл - Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтууд - Тангараг - Ёс зүй - Даатгал /байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн/ - Хамгаалалт, аюулгүй байдал - Мэргэжлийн зэрэг, хөгжил - Маргаан шийдвэрлэх - Гадаадын ажиллах хүчин - ТАВДУГААР БҮЛЭГ ЭМЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

Хуулийн зохицуулалтын хүрээгээ тогтох

Хуулийн төслийн үзэл баримтлалаа батлуулах